



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 10 өдөр

Дугаар А/228

Булган сум

Хилийн цэргийн 0286 дугаар ангийн дахин дамжуулах тоног төхөөрөмжийн цэнэг, тэжээл авах зардалд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хилийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.2, 50.1.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3.1 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны VI/26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хилийн цэргийн 0286 дугаар ангийн заставын дахин дамжуулах тоног төхөөрөмжийн цэнэг, тэжээл авах зардалд 10,000,000 (арван сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Шаардагдах 10,000,000 (арван сая) төгрөгийг 2025 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-т зөвшөөрсүгэй.

3.Хөрөнгийг данс бүртгэлд тусган, ашиглалтад хяналт тавьж ажиллахыг Хилийн цэргийн 0286 дугаар ангийн захирагч (хурандаа Л.Цогтжаргал)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

